

5.1. Санал асуулгын нэгдсэн дүн

Ховд аймгийн төрийн алба, үйлчилгээний гүйцэтгэлийн талаар иргэдээс авсан санал асуулгад үнэлэлт дүгнэлт өгсөн байдал.

Аймгийн иргэдээс хууль тогтоомж, төр засгийн бодлого шийдвэр, төрийн үйлчилгээ иргэдэд хэрхэн хүрч байгаа, орон нутгийн удирдлагын болон төрийн албан хаагчдын үйл ажиллагааны талаар иргэдийн санал асуулгыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг зохион байгуулан явууллаа.

Санал асуулгын дүнд Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасаг, холбогдох хэлтэс, агентлагийн дарга, мэргэжилтнүүдийг оролцуулан сум байгууллагуудад хүрч, ард иргэдтэй уулзан санал бодлыг нь сонсож, сар бүрийн 25-ны өдрийг “Иргэдээ сонсох өдөр” болгон зохион байгуулж, долоо хоногийн 5 дахь өдөр бүр орон нутгийн хэвлэл мэдээллийн бүх байгууллагыг оролцуулан тухайн долоо хоногт аймаг орон нутгийн болон төрийн төв байгууллагаас хийгдсэн ажлыг ард иргэдэд хүргэх зорилго бүхий “Төрийн мэдээллийн цаг” бий болгож, иргэдтэй шууд харилцах 105 дугаарын утсыг нээн ажиллуулсны үр дүнд санал асуулгын дүн өмнөх оны мөн үеийнхээс 0.1 хувиар өссөн дүнтэй гарч байна.



Аймаг, сум	Бүгд	Хөдөлмөрийн насны хүн ам	Судалгаанд оролцогсод
Алтай	3165	1871	94
Булган	9266	5412	271
Буянт	2958	1868	93
Дарви	2649	1583	79
Дуут	2043	1242	62
Зэрэг	3084	1823	91
Манхан	4001	2269	113
Дөргөн	2885	1606	80
Мянгад	3502	2039	102
Мөст	3447	1979	99
Мөнххайрхан	2238	1347	67
Үенч	4541	2609	130
Ховд	3189	1756	88
Цэцэг	2492	1545	77
Чандмана	2956	1733	87
Эрдэнэбүрэн	2635	1655	83
Жаргалант	27153	17410	871
Дүн	82204	49747	2487

Аймгийн хэмжээнд 2487 хөдөлмөрийн насны иргэдээс санал асуулга авч хууль тогтоомж, төр засгийн бодлого шийдвэр, төрийн үйлчилгээг иргэдэд хэрхэн хүрч байгаа, орон нутгийн удирдлагын үйл ажиллагааны талаар ард иргэдийн санал бодлыг судлаж, дүгнэлт хийлээ.

Санал асуулгын явцад иргэдээс төрийн байгууллагатай холбоотой:

-төрийн үйлчилгээг бэхжүүлж, хөнгөн шуурхай ил тод болгож иргэдийнхээ дуу хоолойг сонсож, төр бизнесийн хамтын ажиллагааг сайжруулах

-иргэнд хувь хишиг хүртээхтэй холбогдуулан иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдаж чадаагүй иргэдийн лавлагаа мэдээллийг шуурхай гаргах


-согтууруулах ундаа худалдаалдаг цэгийн тоог багасгаж, хуулийн байгууллагууд шударга ажиллаж, үнэн бодитой шийдвэр гаргах

-ядуурлыг бууруулах, иргэдийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээний хүртээмж хангалтгүй, цалин тэтгэвэр нэмснээр өргөн хэрэглээний бараа, шатахууны үнэ өсч байгаа нь ард иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлсөн

-байгаль орчныг хамгаалах, орон нутгийн инженерийн шугам сүлжээг сайжруулах, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, зээлийн хүүг бууруулж, хугацааг уртасгах

-фермерийн аж ахуйг дэмжих, газар тариаланг эрчимжүүлж, бага оврын техник хэрэгслээр хангах

-Боловсон хүчнийг шилж сонгох, сургаж дадлагажуулах, сонгон шалгаруулахад анхаарлаа хандуулж төрийн нэр хүндийг ард түмний дунд өндөрт өргөж ажиллах



1.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх санал 4.3 оноо буюу хангалттай гэж үнэлсэн байна.

2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх санал асуулгад 4.3 оноо буюу хангалттай гэж үнэлсэн байна.

3.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээний талаарх асуулгад 4.5 буюу хангалттай гэж үнэлжээ.

4. Аймгийн хэмжээнд иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх асуулгад 4.3 буюу хангалттай гэсэн үнэлэлт өгчээ.

Эдгээр үнэлгээний дундаж оноо 4.3 буюу хангалттай гэсэн үнэлэлт авч байна.

Санал асуулганд оролцсон иргэдээс аймгийн хэмжээнд жижиг дунд үйлдвэрийг дэмжих, олон улсын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зам тээвэр, шуудан холбоог хөгжүүлэх, төрийн алба хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, аялал жуулчлалын үйл ажиллагааг өргөжүүлэх, байгал орчныг хамгаалах, өргөн хэрэглээний барааны үнийг бууруулах, мөнгөний ханшны уналтыг зогсоох зэрэг саналууд ирсэнийг аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Засаг даргын Тамгын газрын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.